**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/258 Мандалговь

# Дундговь аймгийн боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.2, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал А/220, А/812, А/475-ыг заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын байгууллагад холбон зуучлах, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: - Дундговь аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: - Тэгш хамруулах боловсролыг дэмжих төслийн бүсийн зохицуулагч

Зөвлөлийн гишүүд:
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичгийн дарга
- Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамран сургалт, сурах бичиг хариуцсан мэргэжилтэн
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын боловсрол хариуцсан гишүүн
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын эрүүл мэнд хариуцсан гишүүн
- Сайнцагаан сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
- Сайнцагаан сумын ерөнхий боловсролын
- Хүмүүнлэг сургуулийн захирал
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны төлөөлөл

4822100942

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын тусламж, үйлчилгээг чанартай зохион байгуулахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ